



Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ, ЖУРМЫН
ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

АУДИТЫН КОД: ХЭА-2025/31-22-ШТА-ГА

**““ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР
ДҮН, ҮР НӨЛӨӨ”-д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ**

Хэрлэн сум 2025 он



**Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор Ж.Ганбаатар**

Утас: 7056-2112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 9977-5390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Билэгсайхан

Утас: 8803-2817 Цахим хаяг: bilegsaikhants@audit.gov.mn

Аудитор Н.Хэрлэнбаяр

Утас: 8905-1308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn

Аудитор Н.Туяа

Утас: 9979-9709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	4
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	5
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	6
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	7
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ ЗӨРЧИЛ ГАРСААР БАЙНА.	11
1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 798.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан боловч 672.5 сая төгрөгөөр дутуу олгосон байна.	11
1.2. Орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй 59, иргэдээс санал авч эрэмбэлээгүй 10 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.	16
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ИРГЭДИЙН АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН БАЙНА.	21
2.1. Төсвийн тухай хуулийг зөрчин 27 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна	21
2.2. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байна.	23
2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг эзэмшигч байгууллага хариуцан ажиллаж байна.	25
БҮЛЭГ 3. АЙМАГ, СУМЫН ИТХ-Д ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙГЭЭС ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	27
3.1. Аймаг, сумын ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 212 төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлээгүй байна.	27
3.2. ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд 192 төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу, 57 төсөл, арга хэмжээг мэдээлээгүй байна.	29
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	31
ДҮГНЭЛТ:	32
ЗӨВЛӨМЖ:	33



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Товчлол	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
АОНХС	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУБ	Олон Улсын байгууллага
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТТХ	Төсвийн тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УБУ	Уулын баяжуулах үйлдвэр



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгтийн дугаар	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл	9
Хүснэгт 2	Төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааны мэдээлэл	10
Хүснэгт 3	ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг	11
Хүснэгт 4	ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлэг	12
Хүснэгт 5	Сумдад олгосон орлогын шилжүүлэг	12
Хүснэгт 6	ОНХС-ийн нийт эх үүсвэр аймаг, сумаар	13
Хүснэгт 7	МТТАТ-ын төлөвлөгөө, гүйцэтгэл сумаар	14
Хүснэгт 8	ОНХС-ийн эх үүсвэрт өмнөх оны үлдэгдлээс төлөвлөсөн байдал	15
Хүснэгт 9	ОНХС-ийн орлого, зарлага, үлдэгдлийн мэдээлэл	16
Хүснэгт 10	Төсөл, арга хэмжээнд санал өгсөн иргэдийн тоо	16
Хүснэгт 11	Иргэдээс санал аваагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал	17
Хүснэгт 12	Хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй төсөл, арга хэмжээ	18
Хүснэгт 13	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний чиг үүрэг	19
Хүснэгт 14	Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний чиг үүрэг	20
Хүснэгт 15	Санхүүжилтийн эх үүсвэр, чиг үүргийг алдаатай төлөвлөсөн төсөл, арга хэмжээ	21
Хүснэгт 16	Аймаг, сумын ИТХ-аас төсөл, арга хэмжээнд хяналт хийсэн байдал	27
Хүснэгт 17	Өмнөх оны шийдвэрийн хэрэгжилт	28



ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэлийн дугаар	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Дүрслэл 1</i>	<i>Худалдан авах ажиллагаа зохион байгуулалтын төрөл</i>	21
<i>Дүрслэл 2</i>	<i>Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн төрөл</i>	22
<i>Дүрслэл 3</i>	<i>Удирдлагын мэдээллийн системд мэдээлэл оруулаагүй, дутуу мэдээлэл оруулсан сум, ТАХ-ны тоо</i>	23



ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралтын дугаар	Тайлбар
Хавсралт 1	Хэнтий аймгийн ОНХС-ийн 2024 оны эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт
Хавсралт 2	Хэнтий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа
Хавсралт 3	Хэнтий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ
Хавсралт 4	Хэнтий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ашиглалт, үр дүн
Хавсралт 5	Хэнтий аймгийн 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд тавих хяналт
Хавсралт 6	Хэнтий аймгийн ОНХС-ийн 2024 оны аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт
Хавсралт 7	ОНХС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт
Хавсралт 8	Хэнтий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний чиг үүргийн нийцлийн байдлын судалгаа
Хавсралт 9	Хэнтий аймгийн сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний хууль журамд заасан чиг үүргийн нийцлийн судалгаа
Хавсралт 10	Хэнтий аймгийн 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний иргэдийн саналын судалгаа
Хавсралт 11	Хэнтий аймгийн 2024 оны ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системийн гүйцэтгэл
Хавсралт 12	Хэнтий аймгийн, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг данс бүртгэлийн судалгаа



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Их Хурлын төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108, “Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” 2025 оны А/08 дугаар тушаалыг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилго:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-нд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;*
- ✓ *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;*
- ✓ *Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянасан, тайлагнасан эсэх асуудлыг тус тус хамруулав.*

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн ЗДТГ, сумын ИТХ, ЗДТГ, багийн Засаг дарга, аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглалаа. Үүнд:

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;



- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-д “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д орон нутгийн хөгжлийн сангийн зорилгыг орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ гэж тодорхойлсон байна.

Журмын 6.8, 7.8-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 26,951.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 20,794.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 362 төсөл, арга хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аар батлуулж, 294 төсөл, арга хэмжээг 17,518.9 сая төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлжээ.

Хүснэгт 1: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл /сая төг/

д/д	Сумын нэр	Төсөл, арга хэмжээний			Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний	
		Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Санхүүжүүлсэн дүн
1	Батноров	13	839.4	839.4	11	651.0
2	Батширээт	19	689.7	659.4	16	615.2
3	Баян-Адарга	13	376.6	376.6	9	215.6
4	Баянмөнх	11	262.0	251.0	9	173.9
5	Баян-Овоо	12	577.6	563.9	11	504.4
6	Баянхутаг	17	618.4	618.4	16	565.5
7	Биндэр	20	656.6	531.5	13	427.3
8	Бор-Өндөр	11	794.0	753.3	9	455.6
9	Бэрх	7	145.5	145.5	7	144.8
10	Галшар	15	786.4	786.4	14	696.2
11	Гурванбаян	6	120.9	120.9	6	116.4
12	Дадал	10	557.6	557.6	7	518.3
13	Дархан	23	705.8	705.8	13	365.2
14	Дэлгэрхаан	10	335.4	335.4	8	247.2
15	Жаргалтхаан	21	678.4	550.4	21	544.6
16	Мөрөн	11	535.5	535.5	9	487.0
17	Норовлин	12	627.5	623.1	11	584.2
18	Өлзийт	6	108.6	108.6	6	104.1
19	Өмнөдэлгэр	25	1,113.7	1,113.7	16	343.6
20	Хэрлэн	17	1,699.4	1,479.3	15	1,333.0
21	Хэрлэнбаян-Улаан	9	112.0	112.0	3	27.0
22	Цэнхэрмандал	33	1,202.3	1,019.7	23	621.4
23	Аймгийн ОНХС	41	13,408.4	8,007.4	41	7,777.3
	НИЙТ	362	26,951.8	20,794.8	294	17,518.9

Биндэр сум ИТХ-ын тогтоолоор батлаагүй 29.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн бол Гурванбаян тосгон нь сумын ИТХ-ын 2023 оны А/18 дугаар тогтоолоор баталсан 11.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бэлчээрийн усан хангамж” төсөл, арга хэмжээг 2024 оны А/13 дугаар төсвийг тодотгон баталсан тогтоолд тусгахгүйгээр хэрэгжүүлсэн байна.



Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 4,851.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 46 ажлыг он дамжин хэрэгжүүлж байгаа бол 22,141.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 318 ажлыг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 2. Төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааны мэдээлэл

мян.төгрөг

д/д	Хэрэгжих хугацаа	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Шилжих	46	4,851.1	2,000.8
2	Шинэ	318	22,141.5	18,824.8
	НИЙТ	364	26,992.6	20,825.6



БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ ЗӨРЧИЛ ГАРСААР БАЙНА.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 798.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан боловч 672.5 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар 2024 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Хэнтий аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 17,789.1 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол улсын төсвийн орлого эхний хагас жилд давж биелсэнтэй холбоотойгоор Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, Хэнтий аймагт ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 798.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 18,587.1 сая төгрөгийг олгохоор баталсан байна.

Хүснэгт 3. ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг

/сая төг/

д/д	Эх үүсвэр	Баталсан төлөвлөгөө	Тодотгосон төлөвлөгөө	Зөрүү
1	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	15,356.9	16,219.1	862.2
2	Газрын тосны нөөц ашигласны төлбөр	416.5	352.3	- 64.2
3	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 100 хувь	282.2	282.2	-
4	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50 хувь	454.1	454.1	-
5	Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ	1,279.4	1,279.4	-
	Дүн	17,789.1	18,587.1	798.0

Сангийн яамнаас Төсвийн тухай хуулийн 59.3 дахь заалт, Монгол Улсын ЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 457 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал"-ын дагуу тооцож Хэнтий аймагт хуваарилагдсан 17,789.1 сая төгрөгийн орлогын шилжүүлгээс 11,479.7 сая төгрөг буюу 64.5 хувийг сумдын ОНХС-д, 6,309.4 сая төгрөг буюу 35.5 хувийг аймгийн ОНХС-д хуваарилж ирүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор аймгийн төсөвт тодотгол хийж, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 18,587.1 сая төгрөг, үүнээс 10,579.7 сая төгрөг буюу 56.9 хувийг 22 сум, тосгоны ОНХС-д, 8,007.4 сая төгрөг буюу 43.1 хувийг аймгийн ОНХС-д олгохоор баталжээ.

Сангийн яамнаас ирүүлсэн тооцооллоос Мөрөн суманд олгох дүнг 900.0 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

Энэ нь Мөрөн сум 2024 онд хэрэгжүүлэх 11 төсөл арга хэмжээнд 535.5 сая төгрөгийг баталж, их хэмжээний хөрөнгө шаардлагагүй байгааг харгалзан аймгийн удирдлагаас шийдвэрлэсэнтэй холбоотой байна.



Цаашид сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59.2.2¹ дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 457 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал"-ын 7.2², 7.3³ дахь заалтын дагуу хуваарилан батлах нь зүйтэй байна.

Сангийн сайдын тушаалаар ОНХНС-аас аймагт олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг 2 дугаар сараас эхлэн олгохоор баталсан байна. ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлгийг улирлаар харуулбал:

Хүснэгт 4. ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлэг

сая.төг

Улирал	Батлагдсан хуваарь	Олгосон орлогын шилжүүлэг	Зөрүү
1	3,100.6	3,100.6	-
2	4,834.8	4,797.7	37.1
3	5,034.3	4,948.9	85.4
4	5,617.4	5,067.4	550.0
Дүн	18,587.1	17,914.6	672.5

Жилийн эцсийн байдлаар ОНХНС-аас нийт 17,914.6 сая төгрөгийг олгож, 672.5 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгосон байна.

Аймгийн Засаг дарга 2-12 сард сумдад олгох орлогын шилжүүлгийн хуваарийг баталсан байна. Аймгийн ОНХС-аас сумдад олгосон орлогын шилжүүлгийг улирлаар харуулбал:

Хүснэгт 5. Сумдад олгосон орлогын шилжүүлэг

сая төг

Улирал	Батлагдсан хуваарь	Олгосон орлогын шилжүүлэг	Зөрүү
1	1,550.3	1,550.3	-
2	2,697.7	2,697.7	-
3	2,987.7	2,802.8	184.9
4	3,344.0	3,538.9	-194.9
Дүн	10,579.7	10,589.7	- 10.0

Аймгийн ОНХС-аас сумдад 10,579.7 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг олгохоос 10,589.7 сая төгрөгийг олгожээ. Санхүүгийн тайлангийн аудитаар Өлзийт тосгонд 10.0 сая төгрөгийг илүү олгосон зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн.

Сумдад олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваариас зөрүүтэй олгосон боловч жилийн эцэст бүрэн шилжүүлсэн байна.

¹ 59.2.2.энэ хуулийн 59.8-д зааснаас бусад хэсгийн 60 хувийг дараах итгэлцүүрийг харгалзан хуваарилах: 59.2.2.1.хүн амын тоо; 59.2.2.2.нутаг дэвсгэрийн хэмжээ; 59.2.2.3.ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ"

² Аймаг, нийслэл нь энэ аргачлалын 3.4-т зааснаас бусад хэсгийн 60 хувийг Төсвийн тухай хуулийн 59.2.2-т заасны дагуу итгэлцүүрийг харгалзан сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилах бөгөөд үүнд энэ аргачлалын 7.1.1-7.1.2-т заасан орлогыг хүлээн авсан сум, дүүрэг нэгэн адил хамаарна.

³ Аймаг, нийслэл нь орлогын шилжүүлгийг энэ аргачлалын 7.2-т заасны дагуу хуваарилахдаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээнээс хамаарах үзүүлэлтийн хувийн жинг дараах байдлаар тооцно."



Аймгийн хэмжээнд ОНХС-ийн эх үүсвэрт нийт 20,771.9 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 19,268.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 6. ОНХС-ийн нийт эх үүсвэр аймаг, сумаар

сая.төг

№	ОНХС	Орлогын шилжүүлэг		Өмнөх оны үлдэгдэл		ТТХ-ийн 60.2.4 "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр"		ТТХ-ийн 60.2.5 ... хандив тусламж, ... дэмжлэг"		Бусад орлого		Малын тоо толгойн албан татвар		Нийт эх үүсвэр	
		төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц
1	Сумын дүн	10,579.7	10,589.7	1,393.7	-	-	-	-	49.9	70.0	143.1	721.1	858.4	12,764.5	11,641.1
2	Аймаг	8,007.4	7,324.8			-	-		302.5					8,007.4	7,627.3
	Нийт дүн	18,587.1	17,914.5	1,393.7	-	-	-	-	352.4	70.0	143.1	721.1	858.4	20,771.9	19,268.4

ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг, тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг, малын тоо толгойн албан татварын орлого, өмнөх оны үлдэгдэл зэрэг 20,771.9 сая төгрөгийн эх үүсвэрийг баталснаас ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгээс 17,914.5 сая төгрөг, тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламжаас 352.4 сая төгрөг, малын тоо толгойн албан татварын орлогоос 858.4 сая төгрөг, нийт 19,268.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

ТТХ-ийн 60 дугаар зүйлийн 60.2.4 дэх заалтын дагуу татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэрийг төлөвлөж, бүрдүүлээгүй бол мөн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5 дахь заалтын дагуу ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн дэмжлэгээс 352.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана" гэж заасныг үндэслэн аймгийн хэмжээнд 282 уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч 205 ААН -ээс 167 ААН-д гэрээ байгуулахаар хүргүүлснээс 59 ААН гэрээг баталгаажуулж, 108 ААН гэрээг баталгаажуулаагүй, 34 ААН-ийн мэдээлэл дутуу, холбогдох боломжгүй шалтгаанаар гэрээ байгуулаагүй, мөн төрийн болон орон нутгийн өмчит 4 газар байна.

Үүнд 108 аж ахуйн нэгж гэрээ баталгаажуулаагүй нь Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг дарга болон нутгийн захиргааны байгууллагаас цуцлах, сунгах санал хүргүүлэх үндэслэлд тусгагдаагүйтэй холбоотой байна.

Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нийгмийн хариуцлагын хүрээнд байгуулсан гэрээгээр 2024 онд 932.0 сая төгрөгийг 59 аж ахуйн нэгж сайн дурын үндсэн дээр төвлөрүүлэхээс аймгийн ОНХС-ийн дансанд 9 аж ахуйн нэгж 302.5 сая төгрөг, Дархан сумын ОНХС-д 49.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Аудитаар:



Тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээ байгуулахдаа гэрээнд “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь аймаг, сумын орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр санхүүгийн дэмжлэг болгож ... сая төгрөгийг” гэж тусгасан нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана” гэсэн заалттай нийцээгүй;

Мөн гэрээнд тусгасан санхүүгийн дэмжлэг болох 610.0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн “Нэр заагдаагүй бусад орлого” дансанд 48 ААН, 322.0 сая төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт дансанд 11 ААН шилжүүлэхээр заасан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2. “Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: ... 60.2.9. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Малын тоо толгойн албан татварын орлогыг 17 сумын ИТХ-ын тогтоолоор чөлөөлж, 8 сум, тосгон орлогын төлөвлөгөөг батлагүй байна.

Малын тоо толгойн албан татварын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн Төсвийн тухай хуулийн 60.2.8 -д заасан үйл ажиллагаанд зарцуулах чиг үүрэгтэй.

Малын тоо толгойн албан татварын орлогоос 14 сум 721.1 сая төгрөгийг төвлөрүүлэх төлөвлөгөө баталснаас 22 сум, тосгон 888.1 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. МТТАТ-ын төлөвлөгөө, гүйцэтгэл сумаар

/сая.төг/

д/д	Сум, тосгоны нэр	Төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	МТТАТ-ыг тэглэсэн СИТХ-ын тогтоол
1	Батноров	-	18.9	18.9	2024.02.27.06
2	Бэрх	-	6.3	6.3	2024.02.27.06
3	Батширээт	30.0	36.2	6.2	
4	Баян-Адарга	55.0	74.4	19.4	
5	Баянмөнх	13.4	41.5	28.1	2024.02.08.01
6	Баян-Овоо	94.0	65.4	(28.6)	
7	Баянхутаг	-	41.3	41.3	2023.12.20.07
8	Биндэр	-	77.9	77.9	2024.02.21.08
9	Бор-Өндөр	-	6.5	6.5	2024.02.28.08
10	Галшар	30.0	31.8	1.8	2023.12.20.03
11	Дадал	35.3	42.3	7.0	
12	Дархан	99.0	56.4	(42.6)	2024.7.08.12
13	Дэлгэрхаан	-	9.1	9.1	2024.02.23.07
14	ХБУлаан	37.0	11.1	(25.9)	2024.02.23.07
15	Жаргалтхаан	26.9	18.4	(8.5)	2024.02.07.09
16	Мөрөн	9.1	34.5	25.4	2024.04.19.18
17	Норовлин сум	60.0	97.1	37.1	
18	Өмнөдэлгэр	109.5	41.9	(67.6)	2024.03.12.a/04
19	Гурванбаян	22.0	14.5	(7.5)	2024.03.12.a/04
20	Хэрлэн	-	67.7	67.7	2023.12.11.30
21	Өлзийт	-	1.8	1.8	2023.12.11.30
22	Тахилгат	-	-	-	2023.12.11.30
23	Цэнхэрмандал	100.0	93.2	(6.8)	
	Дүн	721.1	888.1	167.0	



Улсын хэмжээнд 2023-2024 онд өвөлжилт хүндэрч зудын нөхцөл байдалтай малын тоо толгой хорогдсонтой холбоотой Батширээт, Баян-Адарга, Баян-Овоо, Дадал, Норовлин, Цэнхэрмандал сумаас бусад 17 сум, тосгон малын тоо толгойн албан татварын хэмжээг ИТХ-ын тогтоолоор 0 төгрөгөөр тогтоож, 2024 оны татварыг чөлөөлсөн байна.

Орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлсэн 888.1 сая төгрөгийн малын тоо толгойн албан татварын орлогоос ОНХС-д 858.4 сая төгрөгийг төвлөрүүлж, 29.7 сая төгрөгөөр зөрүү үүссэн нь уг орлогын оны эхэн, эцэст дэх зам яваа орлого, өмнөх оны аудитаар төвлөрүүлэх актын орлого, ОНХС-д төвлөрүүлээгүй орлоготой холбоотой байна.

Биндэр сум орон нутгийн орлогод орсон 34.1 сая төгрөгийн малын тоо толгойн албан татварыг ОНХС-д бүрэн төвлөрүүлээгүй, орхигдуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

- ОНХС-ийн эх үүсвэрт Дадал сум улсын тэргүүний сумын шагналын орлогоос 70.0 сая төгрөгийг, Өмнөдэлгэр сум орон нутгийн орлогоос хууль зөрчин 70.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн зөрчилд санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлсэн байна.
- Хэрлэн сум хашааны үнэ 3.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аймаг, сумын ИТХ-аар ОНХС-ийн өмнөх он үлдэгдлээс 925.2 сая төгрөгийг баталж, 722.6 сая төгрөгөөр дутуу баталсан нь сангийн эх үүсвэрийг бодитой төлөвлөхгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 8. ОНХС-ийн эх үүсвэрт өмнөх оны үлдэгдлээс төлөвлөсөн байдал сая.төг

д/д	Сум, тосгоны нэр	ОНХС-ийн дансны эхний үлдэгдэл	Өмнөх оны үлдэгдлээс баталсан	Эх үүсвэрт батлаагүй дүн
1	Бэрх	54.9	50.6	4.3
2	Баян-Адарга	51.3	44.0	7.3
3	Баянмөнх	53.6	24.5	29.1
4	Баян-Овоо	55.9	38.7	17.2
5	Баянхутаг	82.8	80.1	2.6
6	Биндэр	156.2	101.7	54.6
7	Бор-Өндөр	165.9	124.3	41.6
8	Галшар	92.2	59.5	32.7
9	Дархан	72.8	34.9	37.9
10	Мөрөн	85.6	70.1	15.5
11	Норовлин	84.2	72.5	11.7
12	Өмнөдэлгэр	122.0	99.0	23.0
13	Хурх	39.3	18.4	20.9
14	Хэрлэн	128.8	96.9	31.9
15	Өлзийт	13.0	10.0	3.0
16	Аймаг	389.3	-	389.3
	НИЙТ	1,647.8	925.2	722.6

⁴ 60.2.8.малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшигаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.



Хүснэгтээс харахад ОНХС-ийн эх үүсвэрт 722.6 сая төгрөгийг батлаагүйгээс аймаг 389.3 сая төгрөгийн өмнөх оны үлдэгдлийг батлаагүй, 15 сум, тосгон 333.3 сая төгрөгийн үлдэгдлийг дутуу баталсан байна.

Хүснэгт 9. ОНХС-ийн орлого, зарлага, үлдэгдлийн мэдээлэл

сая төг

д/д	Сум, дүүргийн нэр	ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл	Нийт эх үүсвэр		Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх зарлагын нийт дүн	ОНХС-ийн харилцах дансны эцсийн үлдэгдэл
			төлөв	гүйц		
1	Батноров	55.9	839.4	802.3	651.0	207.2
2	Бэрх	54.9	145.5	101.2	144.8	11.2
3	Батширээт	168.1	659.4	496.8	615.2	49.7
4	Баян-Адарга	51.3	376.6	352.0	215.6	187.7
5	Баянмөнх	53.6	251.0	254.6	173.9	134.3
6	Баян-Овоо	55.9	563.9	496.6	504.4	48.1
7	Баянхутаг	82.8	618.4	579.4	565.5	96.7
8	Биндэр	156.2	480.5	422.6	427.3	151.6
9	Бор-Өндөр	165.9	753.3	629.0	455.6	339.3
10	Галшар	92.2	786.4	728.7	696.2	124.7
11	Дадал	41.9	557.6	522.7	518.3	46.3
12	Дархан	72.8	705.8	681.4	365.2	389.0
13	Дэлгэрхаан	99.9	335.4	244.7	247.2	97.3
14	Хэрлэнбаян-Улаан	28.6	140.8	86.3	27.0	87.9
15	Жаргалтхаан	3.2	550.4	541.5	544.6	0.1
16	Мөрөн	85.6	535.5	490.8	487.0	89.5
17	Норовлин	84.2	623.1	586.5	584.2	86.5
18	Өмнөдэлгэр	122.0	1,113.7	1,017.3	343.6	795.6
19	Хурх	39.3	120.2	94.3	116.4	17.2
20	Хэрлэн	128.8	1,479.3	1,452.7	1,333.0	248.6
21	Өлзийт	13.0	108.6	109.5	104.1	18.3
22	Цэнхэрмандал	60.4	1,019.7	950.1	621.4	389.2
23	Аймаг	389.3	8,007.4	7,627.3	7,777.3	239.4
	Нийт дүн	2,105.9	20,771.9	19,268.4	17,518.9	3,855.4

Тайлант онд ОНХС-д 19,268.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд 17,518.9 сая төгрөгийг зарцуулж, 3,855.4 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байна.

1.2. Орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй 59, иргэдээс санал авч эрэмбэлээгүй 10 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө 18 сум, 4 тосгоны нийт 20,716 иргэнээс санал авсан байна. Энэ нь нийт сонгуулийн насны иргэдийн 42 хувийг эзэлж байна.

Хүснэгт 10. Төсөл, арга хэмжээнд санал өгсөн иргэдийн тоо

сая.төг

д/д	Сумын нэр	Санал өгөх иргэний тоо	Санал өгсөн иргэдийн тоо	Хувь
1	Галшар	1,348	1,027	76%
2	Баянхутаг	1,719	343	20%
3	Баянмөнх	1,116	508	46%
4	Дархан	1,382	520	38%
5	Дэлгэрхаан	1,252	413	33%



6	Жаргалтхаан	1,354	832	61%
7	Цэнхэрмандал	1,459	1,008	69%
8	Өмнөдэлгэр	3,187	725	23%
9	Батширээт	1,684	198	12%
10	Биндэр	2,716	489	18%
11	Баян-Адарга	1,098	209	19%
12	Дадал	1,667	504	30%
13	Норовлин	1,618	1,234	76%
14	Батноров	2,121	846	40%
15	Баян-Овоо	1,265	1,015	80%
16	Мөрөн	1,158	583	50%
17	Хэрлэн	14,146	6,591	47%
18	Гурванбаян	632	73	12%
19	Өлзийт	671	136	20%
20	Бор-Өндөр	5,545	2,887	52%
21	Бэрх	1,300	394	30%
22	Хэрлэнбаян-Улаан	370	181	49%
Нийт		48,808	20,716	42%

Батширээт, Баян-Адарга, Баянхутаг, Биндэр сумдад санал өгсөн иргэдийн тоо 20 хувиас бага байгаа нь багийн Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс санал авах ажлыг хангалтгүй зохион байгуулж байгаатай холбоотой байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 364 төсөл, арга хэмжээг 20,794.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 1,736.2 сая төгрөг санхүүжүүлсэн 34 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжин хэрэгжсэн, 15,782.8 сая төгрөгөөр санхүүжүүлсэн 260 төсөл, арга хэмжээ нь шинээр хэрэгжүүлсэн ажил байна.

Иргэдээс санал аваагүй 663.2 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 15 төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж 10 төсөл, арга хэмжээг 375.6 сая төгрөгөөр санхүүжүүлж хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 11. Иргэдээс санал аваагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал сая.төг

д/д	Сумын нэр	Санхүүжүүлэхээр баталсан төслийн		2024 онд санхүүжилт олгосон төслийн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Адарга	3	112.2	1	46.9
2	Галшар	1	100.0	1	95.0
3	Дадал	2	75.6	1	69.9
4	Жаргалтхаан	2	50.0	2	49.5
5	Норовлин	2	34.2	2	34.2
6	Өмнөдэлгэр	5	291.2	3	80.2
Нийт		15	663.2	10	375.6

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс санал аваагүй, ажлын хэсгээр эрэмбэлээгүй дээрх төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар батлуулж, санхүүжүүлж байгаа нь сумын Засаг дарга болон түүний томилсон ажлын хэсэг нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.1-т “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах”, Төсвийн тухай хуулийн 63.2-т “Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн



Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно”, 63.3-т “Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн ажлын алба ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлд өргөн мэдүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж байгааг илэрхийлж байна.

Биндэр сумын “Мал угаалгын ванн засварлах 2-р баг”, Дархан сум “Сумын төвийн бүжгийн заалыг бүрэн гэрэлтүүлэх, техникжүүлэх” төсөл, арга хэмжээнд иргэдээс санал авч сумын ИТХ-аар Биндэр сум “Малчдад зориулсан сургалт сурталчилгаа”, Дархан сум “Соёлын төв, сумын төвийн гэрэлтүүлэг” нэрээр өөрчлөн батлуулсан байна.

Цаашид урьдчилсан жагсаалтыг гаргахдаа төсөл, арга хэмжээний нэрийг зөв төлөвлөж иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах, санал авсан төсөл, арга хэмжээний нэр, чиглэлийг өөрчлөхгүйгээр сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахад анхаарах шаардлагатай байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 20,771.9 сая төгрөгийн өртөгтэй 362 төсөл, арга хэмжээнээс түүвэрлэн 10 сумын 6,885.8 сая төгрөгийн 150 төсөл арга хэмжээг авч үзэхэд 3,348.9 сая төгрөгийн дүнтэй 59 төсөл, арга хэмжээг сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төлөвлөөгүй байна.

Хүснэгт 12. Хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй төсөл, арга хэмжээ сая.төг

д/д	Сумын нэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний		Сумын ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээний		Хэрэгжилтийн хувь /тоо хэмжээгээр/
		Тоо	Дүн	тоо	дүн	
1	Батноров	13	839.4	8	475.0	62%
2	Баян-Адарга	13	376.6	4	88.0	31%
3	Баянмөнх	11	251.0	3	33.3	27%
4	Баян-Овоо	12	563.9	5	215.2	42%
5	Баянхутаг	17	618.4	9	397.0	53%
6	Дадал	10	557.6	3	155.0	30%
7	Жаргалтхаан	21	550.4	3	33.4	14%
8	Мөрөн	11	535.5	5	260.3	45%
9	Өмнөдэлгэр	25	1,113.7	10	568.0	40%
10	Хэрлэн	17	1,479.3	9	1,123.7	53%
Нийт		150	6,885.8	59	3,348.9	39%

Энэ нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.1.1-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;” Төсвийн тухай хуулийн 63.3-т “Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн ажлын алба ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлд өргөн мэдүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна.



Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлд заасныг зөрчин магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй, ажлын даалгаваргүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлуулж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Биндэр сумын ИТХ-ын тогтоолоор батлаагүй "Авьяас хөтөлбөр" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 29.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, 20.9 сая төгрөгийг зарцуулсан;

Галшар сумын "Түргэн тусламжийн автомашины дулаан граж", "Арвин багийн төвийн барилга"-ын зураг төсөвт магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулаагүй;

Батноров сумын "Идэрмэг багийн төвийн байшин" төсөл, арга хэмжээний зураг, төсөвт магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулаагүй;

Жаргалтхаан сум баталсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолт байхгүй 163.8 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар батлуулж хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлд заасан төлөвлөлтийн шаардлагыг баримталдаггүй, Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30-д заасан зураг төсөл шаардлагатай төсөл, арга хэмжээг тодорхойлох, мэргэжлийн байгууллагаас мэдээлэл авах байдал дутмаг байдгаас шалтгаалж байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сумдаас ирүүлсэн саналд үндэслэн төлөвлөсөн байна.

Ажлын хэсэг сумдаас ирсэн 2024 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 77 нэр төрлийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралдаанаар танилцуулж, хууль, журамд нийцүүлэн эрэмбэлсэн 43 төсөл, арга хэмжээг ИТХ-д хүргүүлсэн байна. ИТХ 8,007.4 сая төгрөгийн 41 төсөл арга хэмжээг тайланд онд хэрэгжүүлэхээр баталж, 7,486.5 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 13. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний чиг үүрэг

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэг бүхий төсөл, арга хэмжээ		Тоо	Санхүүжүүлсэн дүн	Эзлэх хувь
ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх		41	7,486.5	100%
4.2.1.	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;	14	2,951.4	39%
4.2.2.	Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;	17	3,370.5	45%
4.2.3.	Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах;	4	503.0	7%
4.2.4.	Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;	3	568.0	8%
4.2.5.	Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах	3	93.7	1%
4.2.6.	Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх	-	-	0%
4.2.7.	Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;	-	-	0%
4.2.8.	Ажлын байр бий болгох;	-	-	0%

Сумын ОНХС-ийн эх үүсвэрээс 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 12,615.9 сая төгрөгийн 321 төсөл, арга хэмжээнээс тайлант онд 252 төсөл, арга хэмжээнд 9,838.6 сая



төгрөгийг зарцуулсан байна. Үүний 8,902.3 сая төгрөгийн 189 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр, 936.3 сая төгрөгийн 63 төсөл, арга хэмжээг сумдын ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлж Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын чиг үүрэгт нийцүүлэн ажилласан байна.

Хүснэгт 14. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний чиг үүрэг

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэг бүхий төсөл, арга хэмжээ		Тоо	Санхүүжүүлсэн дүн	Эзлэх хувь
ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх		189	8,902.31	90%
4.4.1.	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;	70	2,516.34	26%
4.4.2.	Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;	41	2,847.70	29%
4.4.3.	Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах;	66	3,133.77	32%
4.4.4.	Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;	4	144.72	1%
4.4.5.	Сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах;	6	192.29	2%
4.4.8.	Ажлын байр бий болгох;	2	67.49	1%
4.4.9.	Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа.	-	-	0%
МТТАТ-аар хэрэгжүүлэх		63	936.31	10%
4.5.1.	Бэлчээрийн менежментийг сайжруулах;	-	-	0%
4.5.2.	Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/	8	225.88	2%
4.5.3.	Малын эрүүл мэндийг хамгаалах;	8	157.03	2%
4.5.4.	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;	16	192.68	2%
4.5.5.	Малын чанарыг сайжруулах;	6	44.46	0%
4.5.6.	Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;	6	78.80	1%
4.5.7.	Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;	-	-	0%
4.5.8.	Малын тэжээлийн ургамал тариалах;	2	30.50	0%
4.5.9.	Тэжээлийн нөөц бүрдүүлэх;	4	80.37	1%
4.5.10.	Байгаль орчныг хамгаалах;	2	30.70	0%
4.5.11.	Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/;	2	10.00	0%
4.5.12.	Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа	9	85.89	1%
Нийт		252	9,838.62	100%

Хэрэгжүүлэхээр баталсан нийт төсөл, арга хэмжээнээс ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 39.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг МТТАТ-аар хэрэгжүүлэхээр, МТТАТ-аар хэрэгжүүлэх 106.95 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр алдаатай төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Энэ нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.4-т "Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгаадаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ", 4.5-д "Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа тул цаашид анхаарах шаардлагатай байна.



Хүснэгт 15. Санхүүжилтийн эх үүсвэр, чиг үүргийг алдаатай төлөвлөсөн төсөл, арга хэмжээ

Сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Санхүүжүүлсэн дүн	Журмын заалт	Эх үүсвэр
Дадал	Сумын өвсний фонд, өвс тэжээлийн агуулах барих ажил	33.9	4.5.9	МТТАТ
Мөрөн	Дүүк машины худалдан авах	73.0	4.5.4	МТТАТ
МТТАТ-аар хэрэгжүүлэх		106.9		
Дархан	Шажин баг Чандмань аравтын Эрүүл хүнс хүнсний ногоо тариалах	15.0	4.4.1	ОНХС
Дэлгэрхаан	Мал нядалгааны цэгийн тохижилт	19.5	4.4.8	ОНХС
Цэнхэрмандал	Цаг уурын шинжилгээний хашааг шинээр барих ажлыг гүйцэтгэх	5.0	4.4.3	ОНХС
ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх		39.5		
Нийт		146.45		

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ИРГЭДИЙН АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН БАЙНА.


2.1. Төсвийн тухай хуулийг зөрчин 27 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 22,301.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 320 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Нийт төсөл, арга хэмжээний 16.9 хувьд буюу 54 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 35.3 хувь буюу 113 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 42.5 хувь буюу 136 төсөл, арга хэмжээг гэрээ шууд байгуулах аргаар, 5.3 хувь буюу 17 төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны цахим системээр зарлахгүйгээр шууд худалдан авах гэрээ байгуулан ажил бараа, үйлчилгээг гүйцэтгүүлсэн байна.

Дүрслэл 1. Худалдан авах ажиллагаа зохион байгуулалтын төрөл

сая.төг



Худалдан авах ажиллагааны дүнд 20,091.1 сая төгрөгийн 275 гэрээг бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхээр байгуулсан бол Биндэр сумын “Авьяас хөтөлбөр” төсөл, арга



хэмжээ нь 2023 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж 2024 онд гэрээ байгуулсан байна. Нийт 2024 онд 20,120.9 сая төгрөгийн 276 гэрээг шинээр байгуулсан байна.


Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг бага байгаа учир худалдан авах ажиллагаанд оролцогч орохгүй байх шалтгаанаар 45 худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээг гэрээ байгуулсан оноор нь ангилбал 2020 онд 2, 2022 онд 2, 2023 онд 23, 2024 онд 276 гэрээг байгуулжээ.

Бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулсан 303 төсөл, арга хэмжээнээс 294 төсөл, арга хэмжээнд 17,518.9 сая төгрөгийн санхүүжилтийг ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгосон байна. Харин гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийн явц, ажлын чанар, санхүүжилт хуваарийн дагуу ирээгүй зэрэг шалтгаанаар 9 төсөл, арга хэмжээнд гэрээний дагуу олгох 473.9 сая төгрөгийг олгоогүй байна.

Олгосон санхүүжилтийг задалж үзвэл гүйцэтгэгчид 16,805.7 сая төгрөг, захиалагчийн хяналтын зардалд 92.4 мянган төгрөг, зохиогчийн хяналтын зардалд 74.4 сая төгрөг, зураг төсвийн зардалд 436.1 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Дүрслэл 2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн төрөл



Гэрээнд заасан хугацааг хэтрүүлэн ажлаа гүйцэтгэж хүлээлгэн өгсөн 3 төсөл, арга хэмжээнд 0.6 сая төгрөгийн алданги, гүйцэтгэсэн ажлын чанарын баталгаанд 7 ажилд 90.7 сая төгрөгийг тооцож ажилласан байна.

Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэлд үндэслээгүй, байгуулсан гэрээг мөрдөхгүй бараа нийлүүлээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон зөрчлүүд илэрсэн. Үүнд:

Дархан сумын “Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг сайжруулах” 15.0 сая төгрөгөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээнд 10.5 сая төгрөгийг шилжүүлсэн боловч тухайн ажил хийгдээгүй байна.

Дархан сумын “Тэжээлийн нөөц бүрдүүлэх” 9.9 сая төгрөгөөр малын тэжээл нийлүүлэх гэрээ байгуулсан ажилд санхүүжилтийг бүрэн олгож 3,700.0 мянган төгрөгийн 20 шуудай хивээг тэжээл хүлээн авсан, үлдсэн тэжээлийг хүлээн аваагүй байна.

Бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээнд заасан хугацаанд ажлаа гүйцэтгэж хүлээлгэж өгөөгүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гэрээнд заасны дагуу алдангийг тооцолгүй санхүүжилтийг олгосон байна. Үүнд:



Баянхутаг сум 6 төсөл, арга хэмжээний 5.8 сая төгрөг, Өмнөдэлгэр сум 3 төсөл, арга хэмжээний 2.8 сая төгрөг, Батноров сум 3 төсөл, арга хэмжээний 14.3 сая төгрөг, Баян-Овоо сум 2 төсөл, арга хэмжээний 2.8 сая төгрөг, Жаргалтхаан сум 3 төсөл, арга хэмжээний 2.5 сая төгрөгийн алдангийг тус тус тооцоогүй гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд иргэдээс санал аваагүй 899.4 сая төгрөгөөр 27 ажлыг санхүүжүүлж хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д заасан орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэснийг зөрчсөн байна.

Энэ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг баримтлан төлөвлөөгүйтэй холбоотой байна.

2.2. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байна.

Аймаг, сумын ИТХ-аар 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс 303 төсөл, арга хэмжээг 24,788.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр гэрээ байгуулан ажилласан бөгөөд тайлант хугацаанд 17,243.6 сая төгрөгийн 251 төсөл, арга хэмжээ нь анх төлөвлөсөн зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтоор баталсан түвшинд хүрч бүрэн хэрэгжсэн байна.

Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс 16,953,0 сая төгрөгийн 248 төсөл, арга хэмжээ нь зорилтот түвшний үр дүнд хүрсэн бол 290.6 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрч чадаагүй, хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

Галшар сумын “Түргэн тусламжийн автомашины дулаан гراج” төсөл, арга хэмжээний дулааны шугамыг зургийн дагуу хийгээгүйгээс шалтгаалан өвлийн улиралд ашиглах боломжгүй болсон.

Галшар сумын “Арвин багийн төвийн барилга”-ын шалны гүйцэтгэл хангалтгүй хийгдсэн, цонхны гадна талд хамгаалалтын төмөр торыг зургийн дагуу хийгээгүй.

Баян-Овоо сумын Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2.2 дахь заалтын шаардлагыг хангахгүй 79.7 сая төгрөгийн “Сумын төвд тавих 3.8 км засмал замын зураг төсөв” -ийг хүлээн авсан байна.

Баталсан зураг төсвийн дагуу барилгын ажлыг гүйцэтгээгүй, захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, ажлын хэсэг нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн шалгаж хүлээж аваагүйгээс шалтгаалан эдгээр зөрчлүүд гарсан байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг он дамжуулан төлөвлөсөн, ОНХС-ийн орлогын шилжүүлэг, малын тоо толгойн албан татварын орлого тасарснаас шалтгаалан санхүүжилт оройтсон, байгаль цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдал зэргээс шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон зэрэг шалтгааны улмаас 7,360.3 сая төгрөгийн 50 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжжээ.



Эдгээр дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд 3,867.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн ч гүйцэтгэгчээс хамаарсан шалтгаанаар гүйцэтгэл хангалтгүй байгааг анхаарах шаардлагатай 2 төсөл, арга хэмжээ байна.

Дархан сумын “Тоглоомын талбай байгуулах” 133.9 сая төгрөгийн гэрээ байгуулж 53.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч ажил нь 40 хувийн гүйцэтгэлтэй, ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 5 дугаар сарын 01 хүртэл сунгасан ч гэрээний хугацаанд хүлээлгэж өгөөгүй.

Дархан сумын 2023 оноос он дамжин хэрэгжсэн “Зөөврийн 00 төсөл, арга хэмжээ бүрэн дуусаагүй, ашиглалтад ороогүй.

Тайлант онд 2,019.3 сая төгрөгийн төсөв өртөгтэй 63 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Эдгээр нь төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг буруу тооцоолсны улмаас худалдан авах ажиллагаанд оролцогч орохгүй байх, малын тоо толгойн албан татварын орлого бүрдээгүйгээс санхүүжилт дутагдсантай холбоотой байна.

Иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сумын авто замыг засварлах, гэрэлтүүлэг, камерын хяналтыг нэмэгдүүлэх, цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр 7,646.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 112 төсөл, арга хэмжээг төлөвлөж бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Мөн хүүхдүүдийн тав тухай, аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цэцэрлэг, сургуулийн барилгын засвар хийх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад зориулж 2,476.2 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Баянхутаг сум 2023 онд ОНХС-ийн 59.9 сая төгрөгийн санхүүжилтээр “Саам эмчилгээ” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж эхлүүлсэн бөгөөд 2024 онд 43.6 сая төгрөгийн санхүүжилтээр нэмэлт тохижилтыг хийсэн байна.

Тус сумын Эрүүл мэндийн төв нь зуны улиралд 2 ээлжээр 50-60 иргэнд уламжлалт бариа засал, саам эмчилгээг хийж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Зураг 1.





2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг эзэмшигч байгууллага хариуцан ажиллаж байна.

Бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээний ашиглалтын байдлыг авч үзвэл 16,880.1 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 246 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаж байна.

ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалтын байдлыг салбараар нь ангилж үзвэл:


1. Дэд бүтэц, тохижилт: Сумын төвийн авто замыг сайжруулах, орон нутгийн чанартай гүүрийг барих, засварлах, шинэ суурьшлын бүсэд дэд станц барих, цахилгааны дамжуулах агаарын шугамын өргөтгөл хийх зэрэг ажлуудад 3,540.9 сая төгрөг, гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлэг, камерын хяналтыг нэмэгдүүлэх, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, багийн төвүүдийн гаднах тохижилт засвар зэрэг ажлуудад 3,870.8 сая төгрөгийн 112 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



2. Боловсролын салбар: Сургууль, дотуур байр, анги танхимын засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, цэцэрлэгийн засвар, тавилга, зөөлөн эдлэлийн шинэчлэл зэрэгт 2,374.9 сая төгрөгийн санхүүжилтээр 27 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



3. Соёлын салбарт: 10 сумын соёлын төвд 842.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын өргөтгөл, засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл, зөөврийн тайз, сандал зэргийг шийдвэрлэсэн байна.



4. Эрүүл мэндийн салбарт: Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, барилгын засварт 253.0 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.



Үүнээс гадна 315.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 5 төсөл, арга хэмжээ ашиглалтгүй байна. Үүнд:

Баян-Овоо сумын “Сумын төвд тавих 3.8 км засмал замын зураг, төсөв”;

Цэнхэрмандал, Жаргалтхаан сумын халуун усны барилга;

Галшар сумын түргэн тусламжийн автомашины дулаан г्राж;

Баянхутаг сумын “Арьс шир элдэх үйлдвэрийн тоног төхөөрөмж, барилга зэрэг болно.

Төсөл арга хэмжээг төлөвлөхдөө урьдчилсан судалгаа хийх, иргэдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хөрөнгийг түрээслэх журам, эрх зүйн орчныг бүрэн судлаагүйгээс бий болсон хөрөнгийг ашиглахад хүндрэл үүсгэсэн байна.

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хөрөнгийн бүртгэл, хариуцан ажиллах байгууллага, ашиглалтын зардал, хөрөнгийг ашиглах хэрэгцээ шаардлага зэргийг тооцож ажиллах шаардлагатай байна.



БҮЛЭГ 3. АЙМАГ, СУМЫН ИТХ-д ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙГЭЭС ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1. Аймаг, сумын ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 212 төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.2.2. “Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих” гэсэн сумын ИТХ-ын чиг үүргийн хэрэгжилтийг авч үзвэл нийт хэрэгжүүлсэн 294 төсөл, арга хэмжээний 16 хувь буюу 47 төсөл, арга хэмжээнд хяналтыг хэрэгжүүлсэн бол 84 хувь буюу 247 төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Баян-Овоо болон Мөрөн сумын ИТХ явцын хяналтыг бүрэн хэрэгжүүлж тайлангаар баталгаажуулсан байна.

Хүснэгт 16. Аймаг, сумын ИТХ-аас төсөл, арга хэмжээнд хяналт хийсэн байдал

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний		ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээний		ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасан хяналтыг хэрэгжүүлсэн эсэх			
		Тоо	Санхүүжүүлэх дүн	Тоо	2024 онд олгосон санхүүжилтийн дүн	ИТХ		Дотоод аудит	
						Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1	Батноров	13	839.4	11	651.0	5	6		11
2	Батширээт	19	659.4	16	615.2		16		16
3	Баян-Адарга	13	376.6	9	215.6		9		9
4	Баянмөнх	11	251.0	9	173.9	2	7		9
5	Баян-Овоо	12	563.9	11	504.4	11			11
6	Баянхутаг	17	618.4	16	565.5	11	5		16
7	Биндэр	21	531.5	13	427.3		13		13
8	Бор-Өндөр	11	753.3	9	455.6	5	4		9
9	Бэрх	7	145.5	7	144.8		7		7
10	Галшар	15	786.4	14	696.2		14		14
11	Гурванбаян	7	120.9	6	116.4		6		6
12	Дадал	10	557.6	7	518.3	3	4		7
13	Дархан	23	705.8	13	365.2	1	12		13
14	Дэлгэрхаан	10	335.4	8	247.2		8		8
15	Жаргалтхаан	21	550.4	21	544.6		21		21
16	Мөрөн	11	535.5	9	487.0	9			9
17	Норовлин	12	623.1	11	584.2		11		11
18	Өлзийт	6	108.6	6	104.1		6		6
19	Өмнөдэлгэр	25	1,113.7	16	343.6		16		16
20	Хэрлэн	17	1,479.3	15	1,333.0		15		15
21	Хэрлэнбаян-Улаан	9	112.0	3	27.0		3		3
22	Цэнхэрмандал	33	1,019.7	23	621.4		23		23
23	Аймаг	41	8,007.4	41	7,777.3		41		41
	Нийт дүн	364	20,794.3	294	17,518.9	47	247		294

Батноров, Баянмөнх, Баянхутаг, Биндэр, Бор-Өндөр, Дархан, Дадал гэсэн сумдаас ИТХ-аас хяналт хийсэн талаар баримт материал ирүүлсэн боловч төсөл арга хэмжээг бүрэн хамруулж хяналтыг хэрэгжүүлээгүй, хяналтыг хэрэгжүүлсэн тайлан хангалтгүй байна.

Бусад сумдын хувьд ИТХ-аас хяналт хийсэн талаарх баримт материалыг аудитад ирүүлээгүй болно.



Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа барилга, байгууламжийн ажилд сумдын ЗДТГ нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллуулахаар аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2024 онд 30 төсөл, арга хэмжээнд 92.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Батноров сумын хувьд захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлэхээр аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай 7 төсөл, арга хэмжээнд 10.2 сая төгрөгийн гэрээ байгуулж ажилласан боловч гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгаагаа зуруулаагүй гэсэн шалтгаанаар хяналтын зардлыг олгоогүй байна.

Захиалагчийн хяналтыг хийж, барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах явцад дараах зөрчил дутагдал илэрсэн байна. Үүнд:

Баянхутаг сум - "Сургуулийн урлаг заалыг засварлах" 150.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь зураг төсөлд тусгасны дагуу гүйцэтгээгүй. Зураг төсөл зохиогчтой зөвшилцөж зураг төсөвт өөрчлөлт оруулаагүй.

Галшар сум - Түргэн тусламжийн автомашины дулаан граж 115.6 сая төгрөг, Арвин багийн төвийн барилгын 95.0 сая төгрөгийн ажлыг хүлээн авах комиссыг ЗГ-ын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг зөрчиж байгуулсан. Барилга байгууламжийн хувийн хэрэг байхгүй.

Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ баталсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтыг зөрчсөн, ЗГ-ын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм" -ийн 4.2.1-т заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг байгуулаагүй, журмын 7-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүйгээр барилгыг хүлээн авч акт үйлдсэн зөрчлийг гаргасан байна.

"Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-д гүйцэтгэсэн аудитын хүрээнд 6 албан шаардлага, 6 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхэд 89.7 хувийн биелэлттэй байна.

д/д	Шийдвэрийн төрөл	Өмнөх аудитын шийдвэр		Шийдвэрийн хэрэгжилт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	6	3,199,436.04	6	3,073,636.04	96.1
2	Зөвлөмж	6	9,563,640.90	6	9,563,640.90	83.3
Нийт дүн		12	12,763,076.94		12,637,276.94	89.7

Албан шаардлагын хэрэгжилт: Албан шаардлагын хэрэгжилтийг хугацаанд нь хүлээн авч үнэлэн ажилласан бөгөөд Биндэр сумын "Залуус хөгжлийн төв" ажил 90 хувийн гүйцэтгэл болох 125.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч ашиглалтад бүрэн ороогүй тухай зөрчлийг арилгаж албан шаардлагын хэрэгжилтийг хангаагүй учир Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтын хүрээнд шийдвэрийг хэрэгжилтийг хангуулж ажиллах хүсэлтийг аймгийн Прокурорын газарт хүргүүлэн ажилласан.

Зөвлөмжийн хэрэгжилт: Өмнөх оны аудитаар өгсөн 6 зөвлөмжийг тайлант оны аудитын хүрээнд үнэлэхэд аймгийн ИТХ-д Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9.4 дэх заалтын хүрээнд тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байсан учир 83.3 хувиар үнэлсэн.



3.2. ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд 192 төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу, 57 төсөл, арга хэмжээг мэдээлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэн 2025 оны 5/596 тоот албан бичгээр Сангийн яамны Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг 2024 оны жилийн эцсийн байдлаар 7,443.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 237.7 сая төгрөгийн бараа материал, нийт 7,681.2 сая төгрөгийн хөрөнгийг төрийн байгууллагуудын дансанд орлогоор бүртгэж, 723.6 сая төгрөгийн хөрөнгийг урсгал зардлаар тайлагнасан байна.


Бор-Өндөр сум “Шинэ суурьшлын бүсүүдэд цахилгаан эрчим хүч татахад шаардлагатай зураг төсөв” ажлыг 103.8 сая төгрөгөөр гүйцэтгүүлж хүлээж аван бүртгэлд тусгаагүй байна.

Хэрлэн сум Тэмүүжний гудамжны явган хүний замын ажлын 70 хувийн гүйцэтгэл болох 255.3 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авч бүртгэсэн байна.

Иймд холбогдох журмын дагуу бий болсон хөрөнгийг хариуцагч байгууллагын данс бүртгэлд бүрэн тусгуулж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлагын мэдээллийн системд аймаг, сумын ИТХ-аар баталсан 362 хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг оруулахаас 112 төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн мэдээлсэн бол 192 төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу мэдээлсэн байна. Үүнд төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн мэдээлэл, гүйцэтгэлийн хувь, гүйцэтгэлийн өмнөх, явц, эцсийн фото зураг зэрэг мэдээллийг бүрэн оруулаагүй, төсөл, арга хэмжээний мэдээллийг сольж оруулсан зэрэг алдаа зөрчил илэрч байна.

Мөн 1,814.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 сумын 57 төсөл, арга хэмжээний мэдээллийг оруулаагүй



Үүнээс сумын ИТХ-аар батлуулсан бүх төсөл, арга хэмжээний мэдээллийг Баян-Адарга, Норовлин сум, Гурванбаян, Өлзийт тосгон оруулаагүй байна.



Багийн Засаг дарга, сумын хэмжээнд ОНХС хариуцсан мэргэжилтэн болон ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд мэдээлэл оруулах үүрэг хүлээсэн албан хаагч нь үүрэгт ажлаа бүрэн хэрэгжүүлж төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг бүрэн оруулахгүй байна.

Мөн “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.3 дахь хэсэгт зааснаар орон нутгийн төрийн сангийн төлбөр тооцоо, зарлага хариуцсан мэргэжилтэн нь удирдлагын мэдээллийн системд оруулсан мэдээллийг үндэслэн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохгүй байх талаар арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байна.

Аймгийн ТЕЗ, 22 сум, тосгоны ТТЗ нар ОНХС-ийн 2024 оны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, холбогдох мэдээллийг маягтын дагуу тухай бүр мэдээлсэн байна.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:





ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу эх үүсвэрээр бүрэн төлөвлөж, бүрдүүлээгүй байна.
- ❖ Нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах гэрээ нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9 дэх заалттай нийцэхгүй байна.
- ❖ Төсвийн тухай хууль, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг зөрчиж хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаагүй 59, иргэдээс санал авч эрэмбэлээгүй 10 төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлсэн байна.
- ❖ Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлд заасан төлөвлөлтийн шаардлага хангаагүй 474.1 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг батлуулж хэрэгжүүлсэн байна.
- ❖ Аймаг, сумын ИТХ нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж болон, ОНХС-ийн төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 195 төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу, 57 төсөл, арга хэмжээний мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд оруулаагүй, иргэд олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.
- ❖ ОНХС болон малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлэх 145.5 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг журамд заасан чиг үүргийг алдаатай төлөвлөж хэрэгжүүлсэн байна.
- ❖ ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 798.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгон баталж 692.8 сая төгрөгийг дутуу олгосон байна.



ЗӨВЛӨМЖ:

Аудитын үр дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

- ❖ Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь заалтыг баримтлан ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар судалгаа хийж, төлөвлөж ажиллах
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн оруулах, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт хийж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, журмын 10.3.3-т заасны дагуу арга хэмжээ авч ажиллах

Сүмдын Засаг дарга нарт:

- ❖ Орон нутгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх
- ❖ ОНХС болон малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүргийн дагуу төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлэх
- ❖ “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу Удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналтын талаар мэдээллийг тайлант хугацаанд багтаан бүрэн оруулж ажиллах

Сүмдын ИТХ-д

- ❖ “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын дагуу төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон журмын хэрэгжилтэд ИТХ-ын дэргэдэх хороодоор дамжуулан хяналт тавьж, тайлагнан ажиллах

ҮАГ-т санал:

- ❖ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөж иргэдээс санал авч эрэмбэлэх үйл ажиллагааны зөрчил давтагдаж байгаа учир аудитыг 1 дүгээр улиралд багтаан гүйцэтгэж, шийдвэрийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх боломжтой хугацааг олгох



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2025 оны 06 дугаар сарын 30

Дугаар А/32

Чингис хот

**Аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, МУЕА-ын "Эрх шилжүүлэх тухай" 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг 1 дүгээр хавсралтаар, тогтоосон төлбөрийн актыг 2 дугаар хавсралтаар, хүргүүлсэн албан шаардлагыг 3 дугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Ц.Билэгсайхан/-т үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, түүний биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Аюурбуны/, сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Ц.Билэгсайхан/-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Д.Оюунтуяа/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ж.ГАНБААТАР

232501#

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхарт
И-мэйл хаяг: khentii@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn